# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 47 (524)

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

- *Төрөөс мөнгөний бодлогын талаар 2008 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай*
- *Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2007 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2007 оны арванхоёрдугаар сарын 21 №47 (524)


## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


607. Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 1105

608. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай 1106

609. Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 1106

610. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 1106

611. "Хот байгуулалтын салбарын төсөл"-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай 1106

612. Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай 1107


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


613. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2008 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Дугаар 86 1107

614. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Дугаар 87 1108

615. Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай Дугаар 96 1124


## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ерөнхийлөгчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "нэгэн бүрэн эрхийнхээс илүүгүй хугацаагаар Улсын Их Хурлаас тогтоосон бусад хангамж эдэлж, улсын хамгаалалтад байна." гэснийг "бүрэн эрхийнхээ хугацаа дууссанаас эхлэн нэгэн бүрэн эрхийн буюу 4 жилийн хугацаанд суудлын автомашин болон холбоогоор үйлчлүүлж, төрийн тусгай хамгаалалтад байх бөгөөд энэ талаар тусгайлан шийдвэр гаргахгүй." гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 11.7 дахь хэсэг нэмсүгэй:

"11.7.Улсын Их Хурлын дарга нь бүрэн эрхийнхээ хугацаа дуусснаас эхлэн нэгэн бүрэн эрхийн буюу 4 жилийн хугацаанд суудлын автомашин болон холбоогоор үйлчлүүлж, төрийн тусгай хамгаалалтад байх бөгөөд энэ талаар тусгайлан шийдвэр гаргахгүй."

**2 дугаар зүйл**. Энэ хуулийг 2007 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**. Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9 дэх заалтыг "бүрэн эрхийнхээ хугацаа дуусснаас эхлэн нэгэн бүрэн эрхийн буюу 4 жилийн хугацаанд суудлын автомашин болон холбоогоор үйлчлүүлж, төрийн тусгай хамгаалалтад байх бөгөөд энэ талаар тусгайлан шийдвэр гаргахгүй." гэж өөрчлөн найруулсугай.

**2 дугаар зүйл**. Энэ хуулийг 2007 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын ", эсхүл Улсын Их Хурлаас тогтоосон" гэснийг хассугай.

**2 дугаар зүйл**. Энэ хуулийг 2007 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

### "ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРЫН ТӨСӨЛ"-ИЙН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл**. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2007 оны 8 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан "Хот байгуулалтын салбарын төсөл"-ийн зээлийн хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 12 дугаар сарын 20-ны өдөр | Улаанбаатар хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ, ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд импортолж борлуулсан хүнсний буудай болон мөн хугацаанд импортолж борлуулсан 40.0 мянган тонн буудайн гурилын нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тэг /"0"/ хувьтай тэнцүү байна.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан хугацаа дууссан, эсхүл мөн зүйлд заасан хэмжээнд хүрснээс хойш энэ хууль үйлчлэхгүй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс буюу 2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр | Дугаар 86 | Улаанбаатар хот

### Төрөөс мөнгөний бодлогын талаар 2008 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

1.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2008 онд баримтлах үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг улирал тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монголбанк (А.Батсүх)-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

**Монгол Улсын Их Хурлын 2007 оны 86 дугаар тогтоолын хавсралт**

### ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2008 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Төрийн мөнгөний бодлого нь инфляцийг дунд хугацаанд тогтвортой нам түвшинд байлгаж, санхүүгийн зах зээл, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, мөнгөний бодлогын үр ашгийг дээшлүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад нийцсэн санхүүгийн зах зээлийн бүтэц, дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэгдэнэ. Монголбанк нь төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн хүрээнд бодлогын шийдвэрүүдээ бие даасан байдлаар гаргана. Энэхүү бодлого нь төрийн бодлогын уламжлалыг хадгалсан, зах зээлийн өөрчлөлтийг тухай бүр тусган авч дунд хугацаанд тодорхойлогдсон зорилготой нийцсэн байдлаар хэрэгжинэ.

**1. Мөнгөний бодлогын талаар**

1.1.Төрийн мөнгөний бодлогын гол зорилт нь 2008–2010 онуудад хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийг дунджаар жилийн 6 хувь байлгахад оршино.

1.2.Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ олон улсад нийтлэг хэрэглэгдэж байгаа дэвшилтэт хэлбэрийг улс орны эдийн засгийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан үе шаттай хэрэгжүүлнэ. Бодлогын хэрэгжилт аль болох тогтвортой, үр ашиг нь нэмэгдэж, улам нээлттэй, үр нөлөө сайтай байх нөхцлийг сайжруулна.

1.3.Гадаад валютын албан нөөцийн удирдлагыг боловсронгуй болгон найдвартай байдлыг хангаснаар гадаад төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дээшлүүлэн, нөөцийг импортын 30 долоо хоногийн төлбөрийг гүйцэтгэх хэмжээнээс доошгүй байлгаж, түүний бүтэц, байршил, эрсдэл, үр өгөөжийн зохистой харьцааг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.4.Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтох зах зээлийн тогтолцоог бэхжүүлж, зах зээлийн мэдээллийн болон арилжааны тогтолцооны үр ашгийг нэмэгдүүлэн, төгрөгийн ханш нь макро эдийн засгийн урт хугацааны зорилгод нийцсэн байхыг чухалчилна. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн үр дүнд уян хатан тогтож байх бөгөөд Монголбанкны оролцоо нь зөвхөн богино хугацааны огцом өөрчлөлтийг зөөлрүүлэх хэмжээнд хязгаарлагдана.

1.5.Зээлийн мэдээллийн санг боловсронгуй болгох, төлбөрийн тэнцлийн мэдээллийн хамрах

хүрээг өргөжүүлж, гадаад хөрөнгө оруулалтын тайлан гаргах ажлыг хэрэгжүүлнэ.

1.6.Мөнгөний бодлогыг улс орны эдийн засгийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглүүлж, урт хугацаатай зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, түүний хүүг бууруулна.

**2. Санхүүгийн салбарын үр ашгийн талаар**

2.1.Санхүүгийн салбарын нэгдсэн удирдлага, хяналтыг боловсронгуй болгох зорилгоор Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанкны үйл ажиллагааны уялдааг сайжруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажиллах эрх зүйн орчныг хуульчлан баталгаажуулна.

2.2.Санхүүгийн салбарт гарч байгаа шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнд иж бүрэн шинжилгээ хийж, дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулахын зэрэгцээ олон улсын хөндлөнгийн бие даасан мэргэжлийн байгууллагуудаар үнэлгээ, дүгнэлт хийлгэж ажиллана.

2.3.Банкны байгууллагын үйлчилгээ нь бизнесийн үйл ажиллагааг дэмжин, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээнд оновчтой нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүнийг цогц хэлбэрээр үзүүлэхэд шаардлагатай эрх зүйн болон дэд бүтцийн орчныг сайжруулна. Сургалт, судалгаа хийж нийтэд түгээх, хэрэглэгчийн мэдээллийг баяжуулах ажлыг зохион байгуулахын зэрэгцээ санхүүгийн зуучлалын үндсэн үйл ажиллагааны хүрээг өргөжүүлснээр цогц бүтээгдэхүүн бий болох орон зайг нэмэгдүүлнэ.

2.4.Банк, санхүүгийн үйлчилгээг цогц хэлбэрээр хүргэх боломжийг бүрдүүлэхийн хэрээр банк, санхүүгийн байгууллагуудын хяналт, шалгалтыг нэгдмэл байдлаар хийх шаардлагыг зохистойгоор хэрэгжүүлнэ.

2.5.Үндэсний төлбөр тооцооны системийг улам боловсронгуй болгох, тасралтгүй найдвартай үйл ажиллагаагаар хангах, төлбөр тооцооны дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлэх, шаардагдах техник хангамжийг бий болгох, бэлэн мөнгөний гүйлгээг багасгах, бэлэн бус төлбөр тооцооны давуу талыг ашиглах дунд хугацааны төлөвлөгөөг Засгийн газартай хамтран боловсруулж үе шаттай хэрэгжүүлнэ.

2.6.Ипотекийн хөрөнгөөр баталгаажсан зах зээлийг хөгжүүлэхтэй холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгох, ипотекийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үл хөдлөх эд хөрөнгийн барьцаагаар баталгаажсан, бага хүүтэй зээлийн эх үүсвэрийг гадаад зах зээлээс нийлүүлэх ажлыг Засгийн газартай хамтран зохион байгуулна.

2.7.Хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн хадгаламжийн даатгалын эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

**3. Төв банкны үйл ажиллагааны талаар**

3.1.Монголбанкны үйл ажиллагааны бие даасан, ил тод байдлыг бэхжүүлэхийн зэрэгцээ олон нийтийн өмнө хүлээх хариуцлагыг өндөржүүлэх ажлыг зохион байгуулна. Энэ ажлын хүрээнд Монголбанкны эрсдлийн удирдлагыг бэхжүүлэх, олон нийт, зах зээлтэй харилцах харилцааг илүү үр ашигтай зохион байгуулж, төв банкны үйл ажиллагааны талаархи олон нийтийн боловсролыг дээшлүүлэхэд илүү анхаарна. Монголбанкны үйл ажиллагааг бие даасан, нээлттэй, ил тод болгох, арилжааны банкуудын удирдлага, дотоод хяналтад Монголбанкны зүгээс тавих хяналтыг сайжруулах, дээрх чиглэлүүдээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулна.

3.2.Банкны үйлчилгээний хүртээмж, найдвартай байдал, үр ашгийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг идэвхжүүлэх, энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын албадтай Монголбанк хамтарч ажиллана.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| **2007 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр** | **Дугаар 87** | **Улаанбаатар хот** |

**Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар батлсугай.

2.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтыг Улсын Их Хурлаас баталсан бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөрүүдтэй нягт уялдуулан, Монгол Улсын 2008 оны төсвийн хуулийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч нарыг санхүүжилтийн эх үүсвэрээр хангаж, цаг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газар /С.Баяр/, Монголбанк /А.Батсух/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/ болон холбогдох бусад байгууллагын удирдлагад даалгасугай.

3.Үндсэн чиглэлийн биелэлтийг улирал тутам гаргаж, Засгийн газар дээрээ хэлэлцэж ажиллахын зэрэгцээ Улсын Их Хуралд 2008 оны 10 дугаар сард, 2009 оны 1 дүгээр улиралд багтаан тус тус танилцуулахыг Засгийн газар /С.Баяр/-т үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛУНДЭЭЖАНЦАН**

УИХ-ын 2007 оны 87 дугаар
тогтоолын хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2008 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| Д/д | Зорилт, арга хэмжээ | Хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт | 2008 онд хүрэх түвшин |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| | **Нэг. Макро эдийн засгийн бодлого** | | |
| | **Зорилт 1.** Эдийн засаг, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор макро эдийн засгийн тогтвортой, тэнцвэрт байдлыг хангана. | | |
| 1. | Эдийн засгийн эрчимжилтийг бататгаж, өсөлтийг нэмэгдүүлэх | ДНБ-ий бодит өсөлт, /хувиар/ | 10.1 |
| | | нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ /ам.доллар/ | 1747.3 |
| 2. | Үнэ ханшийг зохистой түвшинд байлгах зорилгоор төрийн зохицуулалтын зарим арга хэрэгслийг ашиглаж, хэрэглээний үнийн индексийг 6 хувьд байлгах бодлогыг баримтлах | хэрэглээний үнийн индекс /хувиар/ | 6.0 |
| 3. | Гадаад худалдааны тэнцлийг сайжруулж, гадаад валютын цэвэр албан нөөцийг өсгөх | импортыг хангах хэмжээ /долоо хоногоор/ | 38.5 |
| | | цэвэр албан нөөц /сая.ам.доллар/ | 1662.5 |
| 4. | Өрийн зохистой удирдлагыг хангаж, гадаад өрийн эдийн засагт үзүүлэх нөлөөг бууруулах | ДНБ-д гадаад өрийн үлдэгдлийн эзлэх хувь /хувиар/ | 55.0-аас хэтрэхгүй байх |
| 5. | Төсвийн зарлага улмаар орлогын бодлогыг сайжруулан, төсвийн зарлагын бүтэц, тайлагналт, гүйцэтгэлийн үр дүнд үндэслэсэн төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгож, ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хувь, хэмжээг бууруулах чиглэл баримтлах | ДНБ-д төсвийн орлогын эзлэх хэмжээ /хувь/ | 44.3 |
| | | ДНБ-д төсвийн зарлагын эзлэх хэмжээ /хувь/ | 46.9 |
| | | ДНБ-д урсгал төсвийн ашгийн эзлэх хэмжээ /хувь/ | 12.0 |
| 6. | Төсвийн үр ашиггүй зардлыг багасгах зорилгоор бүтцийн өөрчлөлт хийж, удирдлагын зардлыг бууруулах, ДНБ-д эзлэх төсвийн алдагдлыг бууруулах бодлогыг баримтлах | ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хэмжээ /хувь/ | -2.5-аас доош байх |
| 7. | Эдийн засаг, нийгмийн салбарт оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж, төрөөс зайлшгүй шаардлагатай гэж үзсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээг өөрийн хөрөнгөөр гүйцэтгээд санхүүжилтээ нөхөн авах нөхцөлөөр хэрэгжүүлэх зарчмыг үр ашигтай хэрэгжүүлэх | ДНБ-д хөрөнгийн зардлын эзлэх хэмжээ /хувь/ | 12.6 |
| 8. | Өрсөлдөөний орчныг бүрдүүлэн хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| **Зорилт 2.** Санхүүгийн салбарыг эрсдлээс хамгаалах механизмыг бүрдүүлж, даатгалын тогтолцоог боловсронгуй болгон, санхүүгийн тайлагналтын олон улсын стандартыг нэвтрүүлнэ. | | | |
| 9. | Монгол Улсын ээлжит зэрэглэлийг ахиулах эдийн засаг, санхүүгийн нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллах | зэрэглэл тогтоогч компаниудын үнэлгээ | "Стандарт энд Пүүрс"-ийн үнэлгээ ВВ |
| 10. | Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системийг бүх суманд нэвтрүүлж, нэгдсэн сүлжээг бүрдүүлэх | - | ЗГСУМС-д бүх сумыг холбоно |
| 11. | Санхүүгийн зах зээлийн байдалд чухал үүрэгтэй үл хөдлөх хөрөнгийн үнийн индексийг тооцох, судлах хүрээнд орон сууцны үнийн индексийг тооцож эхлэх | - | Оны эхний улирлаас орон сууцны үнийн индексийг мэдээлж эхэлнэ |
| 12. | Санхүүгийн зуучлалын өртгийг хямдруулах үүднээс гадаадын урт хугацаатай, хямд эх үүсвэртэй санхүүжилтийн төслүүдийг өргөжүүлэн хэрэгжүүлэх | - | - |
| 13. | Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд санхүүгийн салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах | - | - |
| 14. | Хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгон, хөрөнгийн зах зээлийн арилжаа, төлбөр тооцоог мэдээллийн технологийн шинэ системээр тоноглох | - | - |
| 15. | Хөрөнгийн биржийн өмчийн харилцааг боловсронгуй болгож, өөрчлөх | - | - |
| **Хоёр. Бодит салбарын бодлого** | | | |
| **Зорилт 3.** Хувийн хэвшлийн хөгжлийг эдийн засгийн бүхий л хөшүүргээр дэмжих, шинжлэх ухаан техникийн дэвшлийг үйлдвэрт нэвтрүүлэх замаар шинэ технологид суурилсан үйлдвэрлэл, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ. | | | |
| 16. | Хувийн хэвшил, төрийн хамтын ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх, үндэсний үйлдвэрийг хамгаалан хөгжүүлэх төрийн бодлогыг тодорхой болгох | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 17. | Сумдад ажлын байр нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх, өрсөлдөх чадвартай үйлдвэрлэлийг дэмжих, тэргүүний шинэ техник, технологийг нэвтрүүлэх, уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлэх, бүсийн төв, томоохон хотуудад үйлдвэрлэл технологийн парк байгуулах зорилгоор олон улсын санхүүгийн зах зээлд 1.2 тэрбум ам доллар хүртэл хэмжээтэй Засгийн газрын бондыг борлуулж, мөн санхүүгийн бусад эх үүсвэр дайчлан 300.0 сая хүртэл ам долларыг зарцуулах | парк байгуулж эхлэх хот, аймгийн тоо | 3 |
| | | бондын арилжаа /тэрбум ам.доллар/ | 1.2 |
| | | жижиг, дунд үйлдвэр эрхлэх төвийн тоо | 21 |
| | | боловсруулах салбарын бүтээгдэхүүний ДНБ-д эзлэх хувь | 5.5 |
| 18. | Эрдэнэтийн зэсийн баяжмалыг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх эхлэлийг тавих | - | - |
| 19. | Таван толгойн нүүрсийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх | - | - |
| 20. | Оюу толгойн зэс, алтны ордыг ашиглаж, уул уурхай-металлургийн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах, уг цогцолборыг ашиглахад шаардагдах эрчим хүчний эх үүсвэр, цахилгаан дамжуулах шугам, зам тээврийн сүлжээ, усан хангамжийн барилга байгууламжийг барьж байгуулах түүнчлэн Дархан-Сэлэнгийн бүс нутаг дахь Төмөртэй, Баянгол, Төмөртолгойн төмрийн хүдрийн ордуудыг түшиглэн төмрийн хүдэр олборлох, баяжуулах, боловсруулах үйлдвэр байгуулж хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төр засгийн зүгээс дэмжлэг үзүүлэх | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 21. | Ураны орд газрыг ашиглах эрх зүйн таатай орчныг эн тэргүүнд бүрдүүлэхийн дээр энэ асуудлыг эрхлэн хариуцдаг бие даасан нэгж байгуулж, түүний ажиллах чиг үүргийг тодорхойлох | - | - |
| 22. | Төмөртэй худрийн бүсэд нүүрс, шохойн чулуу, доломит зэрэг металлургийн үйлдвэрлэлд шаардлагатай түүхий эдийн нэмэлт судалгаа хийх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 23. | "Стратегийн ач холбогдол бүхий орд газар"-ын бүртгэл жагсаалтыг батлах | - | - |
| 24. | Асгатын мөнгөний орд газрыг ашиглах бэлтгэлийг хангах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 25. | Газрын тосны хайгуул олборлолтыг нэмэгдүүлж, газрын тос боловсруулах үндсэний үйлдвэр байгуулахыг төрөөс дэмжиж, нүүрснээс нефть бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 26. | Стратегийн хүнсний бүтээгдэхүүн болох буудай, нефть бүтээгдэхүүний улсын нөөцийг нэмэгдүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх | хөрөнгийн хэмжээ /тэрбум төгрөг/ | 100-гаас доошгүй |
| 27. | Эрдэс, түүхий эдийн нөөцийг өсгөх геологийн хайгуул судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх, хувийн хөрөнгөөр геологийн хайгуулын ажил хийгдэж буй зарим ордод хээрийн судалгаа болон суурин ажлын явцад хяналт тавих | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 28. | Хөрш орнуудын болон олон улсын зах зээлийн боломжийг илүү ашиглах, өндөр хөгжилтэй орнуудын зах зээлд бараа бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх боломжийг эрэлхийлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 29. | Эдийн засаг, худалдааны чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, бүсүүдийн дэд бүтцийг бүрдүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 30. | Бөөний худалдааг Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн хүрээнд зохион байгуулах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 31. | Жижиг, дунд үйлдвэрийн чиглэлээр ажиллаж байгаа хэлтэс, алба, сан, төслүүдийг Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын агентлагийн бүтцэд шилжүүлэн Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд сум, дүүрэг бүрт 30-аас доошгүй сая төгрөгөөр Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөрөнгийг нэмэгдүүлж, ажлын байр бий болгох, Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд өгөх зээлийн хүүгийн тодорхой хэсгийг төрөөс хариуцах, зээлийн баталгаа гаргах механизмыг бүрдүүлж шалгарсан төслийг арилжааны банкаар дамжуулан санхүүжүүлэх, уг зээлийн хүүг жилийн 10 хувиас хэтрүүлэхгүй байх | - | - |
| **Зорилт 4.** Түлш эрчим хүчний салбарт шинэчлэл хийж, найдвартай ажиллагааг хангана. | | | |
| 32. | Түлш, эрчим хүчний салбарт шинэчлэл хийж, зах зээлийн зарчмаар ажиллах орчныг үе шаттайгаар хэрэгжүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 33. | Чаргайт, Эгийн голын усан цахилгаан станцыг барих ажлыг эхлүүлэх | хүчин чадал | 228 мВт |
| 34. | Улаанбаатар – Мандалговь - Таван толгой – Оюу толгойн 220 кВт цахилгаан дамжуулах шугам, дэд өртөөг барьж эхлэх | урт, км | 400.0 |
| 35. | Эрдэнэт-Эгийн голын усан цахилгаан станц, Багануур -Чойбалсангийн 220 кВт цахилгаан дамжуулах шугамын зураг, төслийг боловсруулах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 36. | Тэлмэн-Могойн гол-Мөрөнгийн чиглэлд 110 кВт цахилгаан дамжуулах шугамыг барьж, ашиглалтад оруулах | урт, км | 320 |
| 37. | Улаанбаатар хотод дулааны цахилгаан станцын V дахь эх үүсвэрийг барих ажлыг зохион байгуулах | хүчин чадал | 400 мВт |

| | | | |
|---|---|---|---|
| 38. | Шивээ овоо, Таван толгой болон бусад нүүрсний ордод түшиглэсэн орчин үеийн өндөр үр ашигтай, том хүчин чадлын дулааны цахилгаан станц байгуулах ажлыг эхлүүлэх | хүчин чадал | 10000 мВт |
| | Шивээ Овоогийн нүүрсний уурхайд технологийн шинэчлэл хийх | - | - |
| 39. | Багануур, Шивээ Овоогийн нүүрсний уурхайд технологийн шинэчлэл хийх | үйлдвэрлэх түлшний хэмжээ /мян.тн/ | 150.0 |
| 40. | Экологийн цэвэр түлшний үйлдвэрийг Улаанбаатар хотын 2 дугаар цахилгаан станцыг түшиглэн барьж, ашиглалтад оруулах | цэвэр түлшээр хангагдах өрхийн тоо /мянгаар/ | 70.0 |
| 41. | Хийн түлшний салбарыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, төв суурин газарт хийн түлш ашиглах, техник эдийн засгийн үзүүлэлт боловсруулах, зарим аймгийн төвд шингэрүүлсэн шатдаг хийг цэнэглэх цэг барих | хамрагдах аймгийн төв | 8 |
| **Зорилт 5.** Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлж, аюулгүй байдлыг хангана. | | | |
| 42. | Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалтын зохистой тогтолцоог бүрдүүлэх | - | - |
| 43. | Хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэдээллийн улсын хэмжээний нэгдсэн сүлжээг бий болгох | - | - |
| 44. | Хүнсний баталгаат байдлын тогтолцоог олон улсын жишгийн дагуу шинэчлэх | - | - |
| 45. | Хүн амын хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулж, лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлж, нэгдсэн сүлжээг бий болгох, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, нийтийн хоолны чанар, эрүүл ахуйд тавих шаардлагыг өндөржүүлэх | - | - |
| 46. | Мах, махан бүтээгдэхүүний хангамж, эрүүл ахуй, чанарын шаардлагыг дээшлүүлэх зорилгоор Говь-Алтай, Завхан, Хөвсгөл, Өвөрхангай, Дундговь, Ховд, Баян-Өлгий, Сүхбаатар, Булган аймгуудад хэрэглэттэй агуулах бүхий мал нядалгааны газрыг шинээр байгуулахад дэмжлэг үзүүлэх | үйлдвэрийн аргаар боловсруулагдсан махны хэмжээ /мян.тн/ | 19 –өөс доошгүй |
| 47. | Төв суурин газрын хүн амын мах, сүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилгоор эрчим шимт мах, сүүний үүлдрийн үхрийг импортлож, мах, сүүний болон усалгаатай газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг загвар аж ахуйнуудыг бүсчлэн байгуулах хөтөлбөр, төслүүдийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх | үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ /сая литр/ | 25.9 |
| 48. | Төв суурин газар болон хөдөөгийн иргэдийг дотоодын үйлдвэрлэлийн төмсөөр хангах, түүний хадгалалтыг сайжруулах зорилгоор аймаг, сумдын төвд хүнсний ногооны агуулах байгуулах, гахай, шувууны мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,"Гахай", "Дэгдээхэй" төслийг боловсруулж хэрэгжүүлэх | дотоодын хүнсний ногооны хангалтын хувь | 55.0-аас доошгүй |
| | | дотоодын тариалсан төмсний хангалтын хувь | 95 -аас доошгүй |
| 49. | 2008 оныг "Хүнсний хангамж-аюулгүй байдлын жил" болгон зарлаж уг бодлогын хүрээнд мах, гурилын үнийн өсөлтийг хязгаарлаж, хангамж, нийлүүлэлтийг тогтвортой байлгах зорилгоор махны нөөц бэлтгэх, гурилын хэрэгцээг ойрын 3 жилд дотоодоосоо хангах зорилт дэвшүүлэн, улаан буудайг "Буудайн сан"-гаар дамжуулан худалдан авч, 1 тн тутамд 80.000 төгрөгийн урамшуулал олгох, газар тариалангийн техник хэрэгслийг лизингээр ашиглуулах лизингийн төвүүдийг байгуулах | дотоодын үйлдвэрлэлээр хангах гурилын хангалтын хувь | 43.0 |
| | | буудайн хэмжээ /мян.тн/ | 130.0 |
| **Зорилт 6.** Мал аж ахуйн салбарын байгалийн эрсдэл даах чадавхийг бэхжүүлж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хөдөөгийн хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлнэ. | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 50. | Бүс нутгийн онцлогийг харгалзан хот айл, малчдын бүлэг, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд бэлчээрийг гэрээгээр эзэмшүүлэх эрх зүйн орчин бүрдүүлж бэлчээр, усны нөөцийг зохистой ашиглах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 51. | Аймаг дундын отрын бүс нутгуудыг хамгаалалтанд авч усжуулах, материаллаг баазыг нэмэгдүүлэх, түүнийг хариуцсан нэгжийг ажиллуулж, үйл ажиллагаа нь жигдрүүлэх | отрын бүс нутгийн тоо | 3 |
| 52. | Эрчимжсэн аргаар үхэр, хонь үржүүлэхийн зэрэгцээ нутгийн шилмэл үүлдэр, омгийн малыг сонгон үржүүлэх, цөм сүргийн үржлийн төвийн үйл ажиллагааг жигдрүүлэх | цөм сүргийн тоо /мян.толгой/ | 1130.0 |
| 53. | Бэлчээр дэх эвдэрсэн худагт засвар шинэчлэлт хийх, шинээр худаг гаргах, иргэдийн оролцоотойгоор гар худаг гаргах үйл ажиллагааг дэмжих | шинээр гаргах инженерийн хийцтэй худгийн нийт тоо | 1700-с доошгүй |
| | | засварлах худгийн тоо | 375 |
| 54. | Бэлчээр, тариалангийн талбайн хортон мэрэгч, шавжтай тэмцэх ажлыг хүрээлэн буй орчинд халгүй, үр нөлөөтэй дэвшилт технологи, арга хэлбэрээр зохион байгуулах | энгийн болон биологи, химийн аргаар тэмцэх талбай /мян.га-гаар/ | 680.0 |
| 55. | Тариалан тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, малын тэжээлийн үйлдвэрийг сэргээх арга хэмжээ авах | хураан авах ургац /мян.тн/ | 12.0 |
| 56. | Мал амьтны гоц халдварт болон халдварт, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоог нэмэгдүүлэх, үхрийн доголох өвчин болон түгээмэл тархалттай байгаа эрдсийн дутагдлаас үүсэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдварт өвчний тархалт, гаралтыг бууруулах | хамрагдах малын тоог нэмэгдүүлэх хэмжээ | 2.3 дахин |
| 57. | Монгол Улсыг үхрийн цээж өвчнөөр тайван орны жагсаалтад оруулах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | жагсаалтад орсон байх |
| 58. | Цаатан иргэд, тэмээчдийн амьжиргааг дээшлүүлэх, цаа буга, тэмээн сүргийг тогтвортой өсгөх эрх зүйн орчныг сайжруулж тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| **Зорилт 7.** Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах зорилгоор усалгаатай газар тариалангийн хэмжээг нэмэгдүүлнэ. | | | |
| 59. | Услалтын системийн барилга байгууламжийг шинэчлэх, засварлах, шинээр барьж байгуулах, газар тариаланд техникийн шинэчлэл хийх; | усалгаатай нөхцөлд тариалах тариалангийн талбайн хэмжээ /мян.га-гаар/ | 35.0 |
| 60. | Усалгаатай тариалан эрхлэх талбайн хайгуул хийх, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, бэлчээрийн усны хайгуул судалгааг эрчимжүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 61. | Мал аж ахуй, газар тариалан эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх бага оврын трактор, цахилгаан үүсгүүр, хадлангийн болон газар тариалангийн техник хэрэгслийн тоог нэмэгдүүлэх | бага оврын техник, хадлангийн тоног хэрэгслээр хангагдах өрх, аж ахуйн нэгжийн тоо | 4000 |
| **Зорилт 8.** Барилга, хот байгуулалт, газар зохион байгуулалтын төлөвлөлтийг сайжруулж, иргэдийг орон сууцаар хангах, инженерийн шугам сүлжээг өргөтгөх арга хэмжээ авна. | | | |
| 62. | "40000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хот болон бүсийн тулгуур төв хотуудын гэр хороололыг дахин төлөвлөлт хийх замаар орон сууцны хороолол болгох, төвлөрсөн инженерийн хангамжид холбох | ашиглалтад орох орон сууцны тоо | 10000 айл |
| | | орон сууцны ээлд хамрагдах өрхийн тоо | 15000 |

| | | | |
|---|---|---|---|
| 63. | Хүн амыг орон сууцаар хангах зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ипотекийн хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, "40000 орон сууц"-ны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх | - | - |
| 64. | Автомашины зогсоол, унадаг дугуй, тахир дутуу иргэдийн дэд бүтцийн тусгай байгууламж, тэдгээрт тавих шаардлагыг хот төлөвлөлтийн стандартад нийцүүлэх, барилгын зураг төсөвт тусгаж хэвшүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 65. | Замын-Үүд, Цагааннуурын чөлөөт бүс, Хархорин, Эрдэнэ-зуугийн аялал жуулчлалын төв, Таван толгой, Оюу толгой, Цагаан суваргын уул уурхайн цогцолборыг түшиглэсэн бүс нутгийн хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах | ерөнхий төлөвлөгөө хийх тоо | 4 |
| 66. | Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх | ашиглалтад орох барилгын материалын үйлдвэрийн тоо | 10 |
| | | цемент үйлдвэрлэл, /мян тн/ | 300.0 |
| 67. | Хот суурин газрын инженерийн шугам сүлжээг сайжруулах, гэр хорооллыг цэвэр, бохир усны нэгдсэн сүлжээнд холбох ажлыг эрчимжүүлэх | шинэчлэх болон шинээр барих инженерийн шугам сүлжээний урт /км-ээр/ | цэвэр усны шугам 255 |
| | | | бохир усны шугам 108.4 |
| | | | дулааны шугам 42.6 |
| | | цэвэр бохир усны нэгдсэн сүлжээнд холбогдох өрх гэрийн тоо | 3990 |
| 68. | газрын мэдээллийн үндсэний системийг байгуулах ажлыг эхлүүлэх | мэдээллийн системийн бүрдүүлэлт /хувь/ | 40.0 |
| 69. | Хот суурин газрын кадастрын хүрээнд барилга, байшинд чанар, зориулалтын ангилал тогтоож, регистрийн дугаар олгох | регистрийн дугаар олголт /хувь/ | 30.0 |
| 70. | Ундны баталгаат цэвэр усны хангамжид хамрагдах төв суурин газрын хүн амын тоог нэмэгдүүлэх | ундны баталгаат цэвэр усны хангамжид шинээр хамрагдах иргэдийн тоо /мян.хүн/ | 50.0-аас доошгүй |
| | **Зорилт 9.** Эдийн засгийн бүсүүд болон олон улсын чанартай автозамын сүлжээг өргөтгөх ажлыг эрчимжүүлнэ. | | |
| 71. | Азийн автозамын сүлжээний АН-32, АН-4, АН-3 чиглэлийн болон Мянганы замын хэвтээ, босоо тэнхлэгийн автозамыг үргэлжлүүлэн барих. Үүнд: Ховдын Булган-Ханүйн гүүр-Чулуутын гүүр, Хархорин-Цэцэрлэг, Улаанбаатар- Эрдэнэсант, Өлгий-Толбо-Ховдын чиглэлийн замыг барьж ашиглалтад оруулах; Үенч, Дашинчилэн-Орхоны гүүрийн чиглэлийн замыг Улаанбайшинт-Өлгий-Ховд-Ярант, Чойр-Сайншанд-Замын-Үүд, Чулуутын гүүр-Тосонцэнгэл, Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн замыг үргэлжлүүлэн барих; -Өлгий-Толбо-Ховдын чиглэлийн замыг тавьж эхлэх | баригдах автозамын урт /км-ээр/ | 500 |
| 72. | Авто замын хэвтээ, босоо тэнхлэгүүдийг байгуулж, ойрын 5 жилд бүх аймгийн төвүүдийг нийслэлтэй хатуу хучилттай авто замаар холбох бодлого баримтлах | - | - |
| 73. | Улаанбаатар-Мандалговь-Даланзадгадын чиглэлийн хатуу хучилттай автозамын ажлын зураг төслийг боловсруулах ажлыг дуусгаж, зам барих ажлыг эхлүүлэх | эхний ээлжинд барих замын урт /км-ээр/ | 50.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 74. | Улаанбаатар хотын авто замын сүлжээний нэвтрүүлэх чадварыг сайжруулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, Монгол Улсын төмөр замын тээх, нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор зүтгүүр, вагоны паркийг нэмэгдүүлэх | хөрөнгө оруулалтын хэмжээ /тэрбум төгрөг/ | 10.0-15.0 |
| 75. | Аялал жуулчлалын бүс нутгийн автозамыг сайжруулах хүрээнд Хатгал-Жанхай-Тойлогтын чиглэлийн хайрган зам, Хархорин-Хужирт, Хөшөө цайдам-Өлгий нуур чиглэлийн замыг засаж сайжруулан ашиглалтад оруулж, Мөрөн-Хатгалын замыг эхлүүлэх | баригдах автозамын урт /км-ээр/ | 108 |
| 76. | Улсын чанартай автозамын засвар арчлалтыг өргөжүүлж, замын хиймэл байгууламжийг сайжруулах, тэмдэгжүүлэх, замын дэржигнүүрийг арилгах, шаардлагатай хэсэгт замын туузан хашлага тавих | - | улсын чанартай автозам бүрэн тэмдэгтэй болно. |
| **Зорилт 10.** Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, бүх төрлийн тээврийн хөгжлийг эрчимжүүлнэ. | | | |
| 77. | Дамжин өнгөрөх тээврийн тухай Монгол-Орос-Хятадын гурван талт хэлэлцээрийн явцыг эрчимжүүлж эцэслэн тохирох | - | гэрээ бэлэн болсон байна |
| 78. | Говийн болон Зүүн бүсийн төмөр замын сүлжээ байгуулах болон төмөр замыг цахилгаанжуулах, авто хориглолоор тоноглох, техник эдийн засгийн үндэслэл, судалгаа, зураг төслийг боловсруулах | - | ТЭЗҮ- үүдийг боловсруулж дуусгана |
| 79. | "Говийн бүсийн төмөр зам" төслийг хэрэгжүүлж эхлэх | - | - |
| 80. | Замын-Үүдээр төмөр замаар болон авто замаар ачаа нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх | - | - |
| 81. | Говь-Алтай, Увс, Завхан, Баян-Өлгий аймгийн нисэх буудалд хатуу хучилттай аэродром барих ажлыг эхлүүлж, Говь-Алтайд зорчигч үйлчилгээний барилгыг ашиглалтад оруулах | хатуу хучилттай аэродром барих аймгийн тоо | 4 |
| 82. | Нислэгийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулж, Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрөх олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх | жилд дамжин өнгөрөх нислэгийн тоо | 60000-аас доошгүй байх |
| 83. | Улаанбаатарын ойролцоо Хөшигтийн хөндийд олон улсын шинэ нисэх буудал барих ажлыг эхлүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 84. | Дотоодын агаарын тээврийн үйл ажиллагааг өргөжүүлж, олон улсын нислэг, зорчигчдын тоог нэмэгдүүлэх | зорчигчдын тооны өсөлт /хувь/ | 8,0-аас дээш |
| 85. | Хөлөг онгоцны бүртгэлийн ажиллагааг нэмэгдүүлж, далайн худалдааны тээвэрлэлтийн найдвартай үйлчилгээг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх | шинээр бүртгэх хөлөг онгоцны тоо | 200 |
| 86. | Олон улсын жишигт хүрсэн аялал жуулчлалын томоохон цогцолбор, зочид буудал барихыг дэмжих | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| **Зорилт 11.** Орчин үеийн мэдээлэл холбооны технологид тулгуурласан оюуны үйлдвэрлэлийн шинэ салбарыг бий болгох нөхцөлийг бүрдүүлнэ. | | | |
| 87. | Ази, Европыг холбосон мэдээллийн өндөр хурдны холболт үүсгэх техникийн нөхцөлийг судалж шийдвэрлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 88. | Орчин үеийн мэдээллийн технологийн олон улсын сүлжээг ашиглан оюуны хөдөлмөр эрхлэх нөхцөлийг сонирхогч улс орнуудтай хамтран бүрдүүлж, хэрэгжүүлж эхлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 89. | Мэдээллийн технологийн программ хангамжийн түвшинг сайжруулж, "Цахим засаглал" хөтөлбөрийн хүрээнд Засгийн газрын мэдээллийн төв байгуулах, уг хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| 90 | Интернэтийн олон улсын гарцын хурдыг өндөр хурдны технологид шилжүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| | **Гурав. Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого** | | |
| | **Зорилт 12.** Бүсчилсэн хөгжлийн эрх зүйн орчныг сайжруулж бүс нутаг, бүсийн тулгуур төвүүдийн хөгжлийг дэмжинэ | | |
| 91 | Төв, Хангайн бүсийн хойд хэсэгт "Хөвсгөл-Сэлэнгэ", говийн хэсэгт "Галбын говь"-ийн эрчимтэй хөгжлийн дэд бүс байгуулах нөхцөлийг бүрдүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 92 | Бүсийн тулгуур төв хотуудыг түшиглэн түүхий эд бэлтгэх шинэ тогтолцоог бий болгох | үйл ажиллагааны хэрэгжилтээр | |
| 93 | Алтанбулаг, Цагааннуурын чөлөөт бүсэд дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж эхлэх | хөрөнгө оруулалтын хэмжээ /тэрбум төгрөг/ | 10.0-аас доошгүй |
| 94 | Бүсийн захирагчдын албыг байгуулж, тус албаны ажиллах эрх зүйн орчныг хуульчлах, бүсийн тулгуур төвүүдэд чиглэгдсэн хөрөнгө оруулалтыг дэмжих | - | - |
| 95 | Хөдөөгийн сум, суурин газрын эрчим хүчний хангамжийг шийдвэрлэх | эрчим хүчний төвлөрсөн эх үүсвэрт холбогдох сумын тоо | 33 |
| | | сэргээгдэх эрчим хүчинд холбогдох сумын тоо | 13 |
| 96 | Малчин өрхийг эрчим хүчний сэргээгдэх эх үүсвэрээр хангах | малчин өрхийн хамрагдалт /хувиар/ | 100.0 |
| 97 | Хөдөөгийн бүх сумын төвийг гар утасны сүлжээтэй болгох техникийн асуудлыг шийдэж, малчин өрхийг холбоожуулж эхлэх | үүрэн холбооны сүлжээнд холбох сумын тоо | 200 |
| | **Зорилт 13.** Байгалийн нөөцийн менежментийн шинэ тогтолцоог нэвтрүүлж, байгаль орчны бохирдлыг бууруулна | | |
| 98 | Байгаль орчныг бохирдуулсны хариуцлага тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 99 | Байгаль орчныг хамгаалах ажлыг нутгийн иргэдэд түшиглэн явуулах зорилгоор байгалийн нөөцийг иргэдийн нөхөрлөлд эзэмшүүлэх тогтолцоог нэвтрүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 100 | Ойн бодлогын шинэчлэлийг хийж, ойг нөхөн сэргээх, тарьж ургуулах, хортон шавжтай тэмцэх | ойжуулах талбай /га-гаар/ | 10000 |
| | | ойн хортонтой тэмцэх талбай /га-гаар/ | 34000 |
| | | ойн зохион байгуулалт хийх талбай /сая га-гаар/ | 1,5 |
| | | улсын ойн санд хүлээж авах таримал ой /га-гаар/ | 5000 |
| 101 | Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах | түүхий нүүрсний хэрэглээг бууруулах хувь | 30.0 |
| | | агаарт ялгарах нүүрсхүчлийн хийг бууруулах | 1 Гкал дулаан үйлдвэрлэхэд ялгарах давхар ислийг багасгаж 0.53 болгоно |
| 102 | Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор ногоон байгууламжийг өргөжүүлж, ботаникийн цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг эхлүүлэх | талбайн хэмжээ /га-аар/ | 100 |
| 103 | Улаанбаатар хотын утааг бууруулах чиглэлээр зуслангийн айлуудын цахилгаан хангамжийг бүрэн шийдвэрлэх | - | - |
| 104 | Уул, уурхайн олборлолтоор эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх | техникийн сэргээлт /хувь/ | 60.0 |
| | | Биологийн нөхөн сэргээлт /хувь/ | 25.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 105. | Томоохон хот, суурин газрын хог хаягдлыг булах, устгах ландфилийн аргыг нэвтрүүлж эхлэх | ландфилийн арга нэвтрүүлэх газрын тоо | 2 |
| 106. | Химийн хорт бодисоор бохирдсон газар нутгийн хөрс, усыг хоргүйжүүлэх арга хэмжээ авах, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх | - | - |
| 107. | Ган цөлжилтөд нэрвэгдсэн говийн аймгуудын нутаг дэвсгэрийн цаг агаарт зориудаар нөлөөлөх замаар хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх | үүлэнд нөлөөлөх бүсийн төв байгуулах | 5 |
| 108. | Улиастай, Өндөрхаан, Сүхбаатар, Эрдэнэт хотуудын усан хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааг хийж, эрүүл ахуйн шаардлага хангасан ундны цэвэр усаар хүн амыг хангах | хайгуул хийх газрын тоо | 4 |
| | | ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх сумын тоо | 30-аас доошгүй |
| 109. | Усны ундаргыг хамгаалах, ширгэсэн гол горхийг сэргээх, хурын усаар шинээр усан сан, хөв байгуулах, усыг ашиглах, дахин ашиглах, цэвэршүүлэх орчин үеийн технологийг холбогдох бүх салбарт нэвтрүүлэх | булаг, гол горхины эхийг хашиж /тоо/ | 200-аас доошгүй |
| | | усан сан, хөв байгуулах тоо | аймаг бүрт 3-аас доошгүй |
| 110. | Зарим ховордсон амьтныг зориудаар өсгөн үржүүлэх, ховордсон аж ахуйн ашигт ургамлыг тарималжуулах ажлын цар хүрээг нэмэгдүүлэх | тарималжуулах ургамлын төрөл /төрөөр/ | 5 |
| 111. | Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн талаархи эрх зүйн орчныг боловсронгуй болгож, түүний сүлжээг өргөтгөх, орон нутгийн мэдэлд авах тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх | шинээр тусгай хамгаалалтад авах газрын хэмжээ /сая.га/ | 1.0 |
| | **Дөрөв. Нийгмийн бодлого** | | |
| | **Зорилт 14.** Хүүхэд, гэр бүлд чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээг үргэлжлүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, хүний хөгжлийг дэмжих замаар ядуурлыг бууруулна. | | |
| 112. | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай Засгийн газрын хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | - | - |
| 113. | Хүүхдийн мөнгө, гэр бүл, шинэ хүүхэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 114. | Хөдөлмөрийн төв бирж байгуулж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах | ажилгүйдлийн түвшин /хувиар/ | 2.9 |
| | | ажлын байр шинээр бий болгох /мян.хүн/ | 80.0 |
| 115. | Амьжиргааны түвшин тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгох, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэдийн тоог бууруулах, орон гэргүй иргэдийг гэртэй болгох | нийт хүн амд ядуучуудын эзлэх хувь | 31.0-ээс доош |
| | | олгох гэрийн тоо | 10000 |
| 116. | Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх | цалин нэмэгдүүлэх хувь | 20.0-оос доошгүй |
| 117. | Нийгмийн даатгалын сангуудын санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, бие даасан байдлыг хангах, сангийн тодорхой хэсгийг хөрөнгийн зах зээлд оруулж менежмент хийх нөхцөл бололцоог бүрдүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 118. | Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх талаар үе шаттай арга хэмжээг авч, хууль эрх зүйн орчныг нь шинэчлэн, цаашид нийгмийн даатгалын тогтолцоог бие даалгах бодлогыг баримтлах, нийгмийн даатгал төлөгчдийн бааз суурийг өргөжүүлж, төсвөөс татаас өгөх замаар ажил олгогчоос төлдөг нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 10 хувиар тогтоох | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 119. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний үндэслэл, аргачлалыг боловсронгуй болгох программ хангамжийг нэвтрүүлэх | тэтгэвэр нэмэгдүүлэх хувь | 20.0 |
| 220. | 1995 оноос өмнө цэргийн тэтгэвэрт гарсан албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх | - | - |
| 221. | 1995 оноос өмнө хөдөлмөрийн хүнд, хортой, халуун, газрын доорхи нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэх | тэтгэвэр нэмэгдүүлэх /хувь/ | 25-30 |
| 222. | Төрөөс үзүүлэх халамжийн үйлчилгээний зарим төрлийг мэргэшсэн Төрийн бус байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх стандарт, тариф, бүтээгдэхүүний төрлүүдийг гаргах, төрийн халамжийн үйлчилгээний чанарыг боловсронгуй болгох | - | - |
| 223. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргааны баталгааг хангах чиглэлээр Нийгмийн халамжийн багц хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулж мөрдүүлэх, халамжийн тэтгэмжийг нэмэгдүүлэх | халамжийн тэтгэмжийг нэмэгдүүлэх хувь | 20.0 |
| **Зорилт 15.** Бүх шатны боловсролын чанар хүртээмжийг дээшлүүлж, ерөнхий боловсролын сургалтыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлнэ. | | | |
| 224. | Хүүхдийг цэцэрлэгт болон цэцэрлэгийн бус хувилбарт сургалтын хэлбэрээр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах, сургуульд бэлтгэх, сургалтын агуулга, хөтөлбөрийг сайжруулах | сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жин /хувиар/ | 65.0 - аас доошгүй |
| 225. | Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоол, хүнс, ундны усны хангамжийг сайжруулж, Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн "Үдийн цай" хөтөлбөрт хамрагсдын хүрээг өргөжүүлж, хамрагдах анги, бүлгийг нэмэгдүүлэх | хамрагдах анги | 1-5 |
| | | хамрагдах хүүхэд /мянгаар/ | 240.0 |
| 226. | Хүүхдийг 6-н наснаас нь сургуульд элсүүлэн суралцуулж, ерөнхий боловсролын сургалтыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлж эхлэх | 6 настай хүүхдийн хамран сургалт, /хувиар/ | 97.0 |
| 227. | Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэхтэй холбогдуулан сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг боловсронгуй болгож, бага ангийн багш бэлтгэх тогтолцоог өөрчилж, одоо ажиллаж байгаа бага ангийн багш нарыг давтан бэлтгэх, хөдөөгийн сургуулиудын дотуур байрны хангамжийг нэмэгдүүлж, багтаамж, орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах | шинээр нэмэгдэх дотуур байрны орны тоо | 600-аас доошгүй |
| 228. | Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын стандартад үнэлгээ хийж, шинэчлэн боловсруулж мөрдүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 229. | Англи хэлний сургалтын чанарыг сайжруулж, мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэшлийн мэргэжилтэн бэлтгэхэд анхаарах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 230. | Төрийн сургалтын сангийн зээлийн хөрөнгөөр 2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн аймаг, нийслэл, сумын ахлах сургууль тус бүрээс 1 хүүхдийг сонгон шалгаруулж, жил бүр дэлхийн хөгжилтэй орнуудад сургаж, бакалаврын боловсрол олгож эхлэх | - | - |
| 231. | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн уул уурхай болон орчин үеийн аж үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжилтэй ажилтанг түлхүү бэлтгэх | - | - |
| 232. | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг бэхжүүлж, түүнд суралцагчдад төсвөөс сар бүр олгох тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж, бэлтгэх мэргэжилтэй ажилчдын тоог 2 дахин нэмэгдүүлэх | тэтгэмжийн хэмжээ | 45.0 мянган төгрөг |

| | | | |
|---|---|---|---|
| 233. | Боловсролын хуулийн дагуу төрийн өмчийн их, дээд сургуулийн тогтмол зардлыг төрөөс санхүүжүүлэх | - | - |
| 234. | Их сургуулийн хотхон байгуулах асуудлыг судалж, 2008 оноос эхлүүлэх | - | - |
| 235. | Боловсролын тогтолцооны хүртээмжийг дээшлүүлэн өргөжүүлэх, Улаанбаатар хотын хүн амын механик өсөлтийг бууруулах зорилгоор нийслэл хотын дагуул хотууд болон бүсийн төв, тулгуур хотуудад Улаанбаатар хотын их, дээд сургуулийн салбар байгуулахыг төрийн бодлогоор дэмжих | - | - |
| 236. | Насанд хүрэгчдийн тасралтгүй боловсролын эрхзүйн орчинг бүрдүүлж, албан бус боловсролын төвүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлж, сургалтын орчныг сайжруулах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 237. | Сургалтын төрийн сангаас суралцагсдад хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж олгох тогтолцоог өөрчлөх, боловсронгуй болгох | - | - |
| 238. | Хувийн зардлаар гадаадад суралцаж магистр, докторын зэрэг хамгаалсан иргэдийг дэмжих журам гаргах | - | - |
| 239. | Өндөр хөгжилтэй орны магистрантур, докторантурт суралцах зардлыг холбогдох байгууллагад нь олгож, төгсөөд эх орондоо ирж, ажилладаг хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх | - | - |
| 240. | Жилд бэлтгэх аутсорсингийн мэргэжилтний тоог нэмэгдүүлэх | жилд бэлтгэх мэргэжилтний тоо | 4000.0 |
| 241. | Эрдэм шинжилгээний ажлын захиалгын хариуцлагыг нэмэгдүүлж, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх механизмыг боловсронгуй болгох | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 242. | Эрдэм шинжилгээний болон дээд боловсролын сургалтын байгууллагуудын дундын тоноглосон лаборатори байгуулах | | |
| 243. | Шинжлэх ухааны төслийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоо, санхүүжилтийг нэмэгдүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 244. | ШУТ-ийг 2010 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх технологийн дэд бүтцийг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх, дундын ашиглалт бүхий лаборатори, төв, жижиг дунд үйлдвэрүүд бий болгох | - | - |
| 245. | Хөдөөгийн хүн амын соёл урлагийн үйлчилгээг сайжруулж соёлын төвүүдийн техник хэрэгслийн хангамж, барилгыг сайжруулах, соёлын төвийн ажилтнуудын чадварыг дээшлүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 246. | Сумдын номын сангийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, номын фондыг сэлбэн орчин үеийн уран зохиолын болон бизнес, аж ахуйн гарын авлага, номоор хангах | - | - |
| 247. | Улсын болон орон нутгийн хамгаалалтад байдаг түүх, соёлын дурсгалт газар, барилга, байгууламжийн эзэмшил газрын бүсийг тогтоох, газрын төлбөрөөс чөлөөлж, хамгаалалтыг сайжруулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох | - | - |
| 248. | Биет болон биет бус соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 249. | Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын байр барьж эхлэх | - | - |
| **Зорилт 16.** Эрүүл мэндийн салбарын менежментийг боловсронгуй болгож, улсын болон хувийн эмнэлгүүдийн оношлогоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, орчин үеийн иж бүрэн оношлогооны төв байгуулах санаачилгыг дэмжинэ. | | | |
| 250. | Аймаг, сумдын эмнэлэг, цагдаа, хилийн цэргийн автомашины паркыг шинэчлэхэд зориулан 2008 оноос эхлэн 4 жилийн хугацаанд нийт 16-20 тэрбум төгрөг тусгах | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 251. | "Эрүүл Монгол Хүн" хөтөлбөрийн хүрээнд бүх нийтийг хамарсан эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулах | хүн амын үзлэгт хамрагдах хувь | 60.0-аас доошгүй |
| 252. | Халдварт өвчний тархалтыг хязгаарлах, гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөжүүлж, өвчин эсэргүүцэх тарилга, вакцин, эм хангалтыг нэмэгдүүлэх | халдварт өвчнийг бууруулах хувь | 5.0-аас доошгүй |
| | | тарилга, вакцины нөөцлөлт /хувь/ | 20.0-оос доошгүй |
| | | халдварт өвчнийг эмчлэх эмийн хангалт /хувь/ | 90.0-ээс доошгүй |
| 253. | Ард иргэдийн дунд химийн хорт бодисоос урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг өргөжүүлж, хордлогын болзошгүй илрэлийн үед авах арга хэмжээний бэлтгэлийг хангах | - | - |
| 254. | Орчин үеийн иж бүрэн оношлогооны төвийг нийслэл хотод шинээр байгуулах, бүсийн төвүүдийн оношлогооны төвийг чадавхжуулах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 255. | Улаанбаатар хотын яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулах зорилгоор хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх | - | - |
| 256. | Хүн ам, ялангуяа эх хүүхэд болон ядуу, эмзэг бүлгийн хүмүүст хүрэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх | дэлхийн эрүүл мэндийн байгууллагын шалгуур хангасан эх, хүүхдэд ээлтэй эмнэлгийн тоо | 9-д хүргэх |
| 257. | Олон улсын хөл хориот өвчний явуулын лабораторийг байгуулах, шаардлагатай оношлуур тоног төхөөрөмжөөр хангах | явуулын лаборатори байгуулах аймгийн тоо | 2-3 |
| 258. | Эмэгтэйчүүдийн жирэмслэлттэй хавсарсан эрхтэн, системийн өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, витаминжуулах, ураг нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах | 0-5 насны хүүхдийн эндэгдлийг бууруулах, /1000 амьд төрөлтөнд/ | 24 |
| | | нялхасын эндэгдлийг бууруулах, /1000 амьд төрөлтөнд/ | 18 |
| | | эхийн эндэгдлийг бууруулах /100000 амьд төрөлтөд/ | 69 хүртэл |
| | | шинээр барих төрөх орны тоо | 600 ор |
| 259. | Эмнэлэг дундын мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах | сүлжээнд хамрагдах байгууллагын тоо | 14 |
| 260. | Алсын зайн оношлогооны үйл ажиллагааг өргөжүүлж, техник хэрэгсэл, мэргэжилтнээр хангах | - | - |
| 261. | Сумдын эмнэлгийг халдварт өвчнийг оношлох лабораторийн техник, хэрэгслээр хангах | - | - |
| 262. | Сум, өрхийн эмчийг бэлтгэх тогтолцоо болон хөдөө орон нутагт ажиллах эмч нарын урамшууллыг боловсронгуй болгох замаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмчийн хангалтыг сайжруулах | сумын эмнэлгийн эмчийн хангалт /хувь/ | 100.0 |
| 263. | Аймгийн төвийн бус, хөдөөгийн сум, тосгон, сум дундын эмнэлэгт ажиллаж байгаа их эмчид 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний урамшуулал олгох | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 264 | Нийслэлийн дүүргүүдэд өвөл, зуны болон багийн спортын иж бүрэн цогцолбор байгуулах, аймгийн төвүүдэд спортын ордон, сумын төвүүдэд соёл, спортын төв барих ажлыг үргэлжлүүлэх | - | - |
| 265 | Бээжингийн зуны олимпийн их наадамд оролцох тамирчдын эрхийг нэмэгдүүлэх үүднээс бэлтгэл сургуулилтад шаардлагатай санхүү, зохион байгуулалтын арга хэмжээ авах | олимпод оролцох эрх авах тамирчдын тоо | 15-17 |
| 266 | Монголын бүх ард түмний XII их наадмыг зохион байгуулах | хүн амын хамрагдалт /хувь/ | 60.0 |
| | **Тав. Гадаад бодлого, батлан хамгаалах** | | |
| | **Зорилт 17.** Монгол Улсын олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагааг улам бататгана | | |
| 267 | Хөөр хөрш болон тэргүүлэх ач холбогдол бүхий гүрнүүд, бүс нутгийн болон Европын холбооны улсуудтай дээд, өндөр хэмжээний харилцан айлчлалыг тогтмолжуулж, яриа хэлэлцээрийн давтамжийг хадгалах, улс төрийн зөвлөлдөх уулзалтыг тогтмол хийх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | хамтын ажиллагаа улам өргөжиж, гадаадын хөрөнгө оруулалт өсно |
| 268 | АНУ-тай гурав дахь хөршийн хэмжээнд идэвхитэй хамтран ажиллах иж бүрэн түншлэлийн ерөнхий хэлэлцээр, харилцааны зарчмуудын тухай улс төрийн баримт бичиг, Мянганы сорилтын сантай ерөнхий гэрээ байгуулж, төмөр зам, эрүүл мэнд, боловсролын төслүүдийг хэрэгжүүлэх | - | мянганы сорилтын сангаас хөрөнгө авч эхэлнэ |
| 269 | НҮБ, түүний системийн байгууллагуудын олон талт үйл ажиллагаанд идэвхитэй оролцон, олон улсын хамтын нийгэмлэгт эзлэх байр суурийг улам бэхжүүлэх, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд НҮБ, түүний байгууллагуудтай хамтран ажиллах | - | МХЗ-уудын хэрэгжилт сайжирна |
| 270 | Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээр, хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, АСЕАН-ы яриа хэлэлцээрийн салбар дундын түншлэлийн статустай болохыг зорих, Чианг Майн санаачилгын хэлэлцээрт нэгдэн орох чиглэлээр ажиллах, Зүүн Азийн хамтын нийгэмлэгт нэгдэх талаар ажиллах | - | бүс нутгийн хамтын ажиллагаан дахь Монгол Улсын оролцоо нэмэгдэнэ |
| 271 | Гадаад харилцааны бодит шаардлага, улс орны язгуур эрх ашгийг харгалзан хилийн чанадад шинээр ДТГ нээх асуудлыг судалж шийдвэрлэх, Улаанбаатарт Канад, Австрали, Тайланд болон бусад орны ЭСЯ нээлгэх чиглэлээр ажиллах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| | **Зорилт 18.** Улс орны батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгох эрх зүйн зарим өөрчлөлтийг хийж, зэвсэгт хүчний болон дайчилгааны чадавхийг дээшлүүлнэ | | |
| 272 | Бүс нутгийн өнөөгийн байдал, улс орны аюулгүй байдлын орчин, батлан хамгаалах үйл ажиллагаанд нийцүүлэн хууль эрх зүйн холбогдох шинэчлэлийг хийх, стратеги боловсруулах | - | батлан хамгаалах эрх зүйн орчин сайжирна |
| 273 | Аюулгүй байдлын орчин, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодит нөхцөл боломжтой уялдуулан улсын дайчилгааны бодлого төлөвлөлтөд тодотгол хийх, дайчилгааны бэлтгэл, нөөцийн бэлтгэл үүрэгтэн, төрийн болон орон нутгийн удирдах бүрэлдэхүүний бэлтгэл сургалтыг зохион байгуулах | - | бэлтгэл нөөцийн чадвар дээшилнэ |
| 274 | Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтын төвийн нэгдсэн стандартыг боловсруулж, бүсийн төвүүдэд байгуулж эхлэх | эхний ээлжинд хамрагдах бүс | 2 |
| 275 | Энхийг сахиулах ажиллагааны олон улсын сургалтын төвийг байгуулж, бүс нутгийн хэмжээний дадлага, сургалтыг явуулах нөхцөлийг бүрдүүлэх | - | зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний чадавхи сайжирна |

| | | | |
|---|---|---|---|
| 276. | НҮБ-ын мандатын доор явагдаж байгаа энхийг сахиулах, аврах, сэргээх, босгох болон олон улсын бусад ажиллагаанд Монгол Улсын зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний бэлтгэлийг хангаж оролцох оролцоог нэмэгдүүлэх, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох үүрэг бүхий шинээр байгуулагдсан батальоны орон тоо, зэвсэг техникээр хангах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 277. | Зэвсэгт хүчний зарим анги, салбарыг хууль, тогтоомжийн хүрээнд улс орны бүтээн байгуулалтын ажилд оролцуулах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| **Зорилт 19.** Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажил хөдөлмөр эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхэд мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг шинэчилж, ажлын үр нөлөөг дээшлүүлнэ. | | | |
| 278. | Хилийн боомтод мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, хяналтыг чангатгах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 279. | Хил, гааль, цагдаагийн байгууллагуудын ажиллах нөхцөлийг сайжруулж, лаборатори байгуулах | - | - |
| 280. | Хүн амын хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн дотоодын болон импортын хүнсний бүх бүтээгдэхүүнд лабораторийн нарийн шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх, баталгаажуулалтын түвшинг дээшлүүлэх | лабораторийн шинжилгээнд хамрагдалт /хувь/ | 70.0 |
| 281. | Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагаанд тавих хяналтыг эрс сайжруулах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| **Зорилт 20.** Онцгой байдлын албыг бэхжүүлж, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадварыг дээшлүүлнэ. | | | |
| 282. | Улсын нөөцийн байршил, нэр төрөл, тоо хэмжээг шинэчлэн тогтоож мөрдүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 283. | Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулж, гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлагыг зохион байгуулах | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 284. | Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээлэл холбооны сүлжээг сайжруулах, түүний техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх | - | эрт зарлах мэдээллийн тогтолцоо бүрдэж эхлэнэ |
| 285. | Олон улсын эрэн хайх, авран туслах үйл ажиллагааны тогтолцоонд хамрагдах асуудлыг судалж шийдвэрлэх | - | - |
| 286. | Аймаг, нийслэлийн онцгой байдлын хэлтэс, газар, аврах отряд, салбар, гал унтраах болон мэргэжлийн аврах ангиудын техник, багаж хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 287. | Байгалийн гамшиг, үйлдвэрийн ослын үед шаардагдах гамшгийн нөөцийг бүрдүүлэх | - | - |
| 288. | Болзошгүй гамшгийн аюулыг бууруулах чиглэлээр гамшгийн эрсдэл, эмзэг байдлын үнэлгээг тогтмол хийж хэвшүүлэх | - | - |
| 289. | Иргэд, олон нийтэд тулгуурласан гамшгаас хамгаалах удирдлагыг хөгжүүлэх | - | - |
| 290. | Гамшгийн хяналт, шалгалтын ажлын баталгаажуулалтын түвшинг дээшлүүлэх | - | - |
| | **Зургаа. Засаглал, эрх зүйн шинэчлэл** | | |
| | **Зорилт 21.** Эдийн засаг, нийгмийн бүх хүрээнд хариуцлагын тогтолцоог эрс дээшлүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй, шуурхай хүргэж, ил тод байдлыг хангахад ахиц гаргана. | | |
| 291. | Иргэний эрх, эрх чөлөө, шударга ёс, ил тод байдлыг баталгаажуулсан хууль хяналтын тогтолцоог бүрдүүлж, эдийн засгийн хөгжлийн чадавхийг нэмэгдүүлэх | - | - |
| 292. | Бүх салбарт байгаа хариуцлага тооцох механизмын эрх зүйн үндсийг дахин нягтлан үзэж, чангатгах, боловсронгуй болгох | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 293. | Төрийн албаны хүнд суртлыг багасгах замаар төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг тогтоож, хариуцлага хүлээлгэх зарчмыг тодорхой болгох арга хэмжээг авах | - | - |
| 294. | Улаанбаатар хотод, төрийн албан ажлын үйлчилгээний хэрэгцээнд 100 километрт 13 литрээс илүү түлш хэрэглэдэг хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж ихтэй автомашин хэрэглэхийг хориглох | - | - |
| 295. | Яам, агентлагийн болон төрийн захиргааны дунд, доод шатны түвшинд бүтцийн өөрчлөлт хийж, цомхон, чадварлаг удирдлагын бүтэц бий болгох | - | - |
| 296. | Орлогоороо санхүүждэг агентлагуудыг төсвийн санхүүжилтээр санхүүждэг зарчимд шилжүүлэх | - | - |
| 297. | Аймгийн төвийн болон аймгийн төвд ойрхон оршдог сумдыг нэгтгэж, засаг захиргааны нэгжийн шинэчлэл хийх асуудлыг шийдвэрлэх | - | - |
| 298. | Сумдын Засаг даргын Тамгын газрын ажиллах нөхцөлийг сайжруулах, боловсон хүчний чадавхийг сайжруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | - | - |
| 299. | Бие хүний өгөгдөл, гарын хурууны хээ, нүдний цөцгийн тусгалын мэдээллийн улсын нэгдсэн сан байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |

| | | | |
|---|---|---|---|
| 300. | Сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгож, сонгуулийн хууль тогтоомж зөрчигчдөд, ялангуяа сонгууль зохион байгуулж буй ажилтанд хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэх | - | - |
| 301. | Монгол Улсын Их Хурлын 2008 оны ээлжит сонгуулийн өмнө хүн амын бүртгэл, тооллогын тоо, мэдээний зөрүүг арилгах, бүдлиангүй болгох | - | - |
| 302. | Гэмт хэрэг, гэм буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зохистой механизм, эрх зүйн үндсийг бүрдүүлж мөрдүүлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 303. | Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас торгуулийг бэлэн мөнгөний хэлбэрээр оногдуулж байгаа журмыг өөрчилж, төлбөр тооцоог бэлэн бусаар хийх асуудлыг шийдвэрлэж мөрдөх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 304. | Иргэний бүртгэл мэдээлэл, шилжих хөдөлгөөн, гадаадын иргэн, харьяатын асуудлаарх төрийн үйлчилгээг нэгдсэн сүлжээнд оруулж иргэдэд шуурхай үйлчлэх | үйл ажиллагааны хэрэгжилтээр | - |
| 305. | Хууль тогтоомж хоорондын зөрчлийг судлан арилгах арга хэмжээг эхлүүлэх | - | - |
| 306. | Засаглал, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд УИХ-ын Байнгын хороодыг орчин үеийн ажлын техник, хэрэгслээр хангах | - | - |
| 307. | Сумдад цагдаагийн кобан борих ажлыг эрчимжүүлэх | кобаны тоо | 80 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2007 оны 12 дугаар сарын 20-ны өдөр** | **Дугаар 96** | **Улаанбаатар хот**

### Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ тогтоох тухай

Гаалийн тарифын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл импортолсон хүнсний буудай болон энэ хугацаанд импортолсон 40.0 мянган тонн буудайн гурилын гаалийн албан татварын хувь, хэмжээг тэг /"0"/ хувьтай тэнцүү байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр хэсэгт заасан хугацаа дууссан, эсхүл мөн хэсэгт заасан хэмжээнд хүрснээс хойш энэ тогтоол үйлчлэхгүй.

3. Хилийн боомтуудаар импортлох буудайн гурилын хэмжээг тогтоож, хяналт тавьж ажиллахыг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.

4. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс буюу 2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>>** эмхтгэлийн зөвлөл.
Улаанбаатар-12 Төрийн ордон
☎ 265958
Индекс: 14003
Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Хэвлэлийн хуудас 2.5
☎ 329487